

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр

сарын 22-ны өдөр

№ 20

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн 31.3.5 дахь заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны жилийн үйл ажиллагаа болон аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн асуудлаар дүгнэлт гарган Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсгийн 76.1.11 дэх заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсгийн 9.13.13 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК нь “Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн гэж” дүгнэсэн болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Банкны 2025 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-ийн дүгнэлтийг хянан хэлэлцээд Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэсэн болохыг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:


1. **ТОГТООХ НЬ:** Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүн, “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөл хянан хэлэлцээд энэхүү тогтоолын Хавсралт №01-ийн дагуу дүгнэсүгэй.
2. **ТОГТООХ НЬ:** Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүн, Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлийн хамт эцэслэн батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.



3. **ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг эцэслэн батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хатагтай Т.Дарьбум-д даалгасугай.
4. **ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга хатагтай В.Янжинлхам нарт Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүн, Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэх, танилцуулах зэрэг дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.


БАТЛАВ





Түдэв овогтой Дарьбум


Дашдава овогтой Хулан



Харада Ясүнари



Цагаач овогтой Баатарсайхан


Кисабүро Иший


Жон Ло


Амарбаясгалан овогтой Тамир


Ханс Аарт Йонгеганс


Батболд овогтой Амарсанаа



Хавсралт №01

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүн, хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэв.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнг Банкны Гүйцэтгэх удирдлагаас танилцуулсныг хүлээн авч, “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайланг Банкны санхүүгийн байдал, үр дүнг СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж дүгнэв.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

№ 23

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:


ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн 31.3.1 дэх заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсгийн 9.13.1 дэх заалтад Төлөөлөн удирдах зөвлөл Банкны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлахаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Хиймэл оюун ухаан (AI) стратегийг хэрэгжүүлэх, дижитал шилжилт, автоматжуулалтыг эрчимжүүлэх хүрээнд Банкны үр ашигт байдлыг дээшлүүлэх, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухааныг үйл ажиллагаанд өргөн хүрээнд үр дүнтэй ашиглах, эрсдэл, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, активын удирдлагыг сайжруулах, газар, нэгжийн зорилго, чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг шинэчлэх, ажлын байрны давхардлыг арилгах зорилгыг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** Банкны Гүйцэтгэх захирлаас шинэчлэн танилцуулж буй “ХААН Банк ХК-ийн зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №01-ийн дагуу баталж, батлагдсан бүтцийг 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхлэхийг санал нэгтгэйгээр баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д шинэчлэн батлагдсан “ХААН Банк ХК-ийн зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц”-ийн хүрээнд газар, нэгжийн зорилго, чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг нарийвчлан тодорхойлохыг үүрэг болгосугай.
- 3. ТОГТООХ НЬ:** Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ



Дашлаваа овогтой Хулан

Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонгеянс

Батболд овогтой Амарсанаа

Дашдаваа овогтой Хулан

Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонтеяанс

Батболд овогтой Амарсанаа

Дашдаваа овогтой Хулан



Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан

Кисабүро Иший

Жон Ло

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонгеянс

Батболд овогтой Амарсанаа